



НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Завхан аймагт 2023 онд хэрэгжсэн улсын болон орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллага (хэлтэс, агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар)-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.


ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт
4. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
5. Аймгийн эдийн нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ
6. Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт
7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
8. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
9. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ
10. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ
11. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт



ДӨРӨВ: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЦАХИМ САНГ НЭВТРҮҮЛЭН, ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системийг нэвтрүүлж 24 сум, хэлтэс агентлаг, байгууллагуудыг холбон мэдээ тайлан хэрэгжилт, үүрэг даалгавр зэргийг цахимжуулж, цаасаар авах байдлыг зогсоож цахимжилтийг эрчимжүүллээ.




ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО



АЛСЫН ХАРАА - 2050
- Урт хугацааны хөгжлийн бодлого -



Хөгжлийн зорилтот хөтөлбөр
- Урт хугацааны хөгжлийн бодлого -



МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ
- Дунд хугацааны хөгжлийн бодлого -



Activate Windows
Go to Settings to activate Windows.

ЗГХЭГ болон Хяналт хэрэгжүүлэх газрын зөвлөмж, хяналт шинжилгээ үнэлгээний мөрөөр Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гарган холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

БАТЛАВ.
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.МЯГМАРСҮРЭН

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үзүүлэлт	Хариуцах нэгж
Нэг. Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах талаар:		
1.1	Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хүрээнд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц, үе шат, хэрэгжих хугацаа, гарах үр дүн, өмнөх жилийн гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудал зэргийг нэрийнчлэн судалж, судалгааны үр дүнг төлөвлөлтөд ашиглаж хэвшиж;	ХБТХОХ
1.2	Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5.2.13-д заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог хангаж ажиллах;	
1.3	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг боловсруулахдаа тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж, эдийн засаг, нийгмийн төлөв байдлын талаарх албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, салбарын бодлоготой уялдуулан аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн онцлогийг харгалзан тодорхойлох.	
Хоёр. Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар:		
2.1	Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, тухайн жилийн хэрэгжилтийг бүрэн хангах;	БҮХ ХЭЛТЭС
2.2	Бодлогын баримт бичгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хэрэгжилтийг үр дүнд чиглүүлэн зохион байгуулж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж ажиллах;	
2.3	Монгол Улсын хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудтай хамтарч ажиллах;	
2.4	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын хууль тогтоомж тогтоол шийдвэрийн аймагт заагдсан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах.	
Гурав. Хэрэгжилтийн тайлагналыг сайжруулах талаар:		
3.1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг богино хугацааны үр	



Бодлогын баримт бичгийн үр нөлөө, иргэдийн үнэлгээний үр дүн, зөвлөмж, тайланг Монгол улсад ил тод байдал олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь төсөлтэй хамтран хийж гүйцэтгэлээ.




Иргэдийн төсөв-2023 орон нутгийн төсвөө боловсруулан ямар хэмжээний орлогыг аль салбараас төвлөрүүлэн, үүнийг ямар бодлоготойгоор юунд зарцуулахыг заасан богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулан иргэддээ ойлгомжтой, нээлттэй, ил тод, хүртээмжтэй хүргэхийг зорьж товхимлыг холбогдох мэдээлэл, зураг ашиглан иргэддээ хүргэсэн.





Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээр тогтмол зөвлөмж заавраар ханган ажиллаж байна.



ТАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий Сайддын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Албан даалгавар, ЗГХЭГ-ын даргын тушаалын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь



заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 102 шийдвэрийн орон нутагт даалгасан 194 заалтыг хяналтанд авч, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжилт аймгийн дүнгээр 87.43 хувьтай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар анхаарч 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөө гаргуулан ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцон ажилласан.

2023 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 7 заалт 30 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ /Хүчингүй болсон хяналтаас хасуулах тухай санал/
Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай 2003-05-30 Дугаар 2003-1 15.2.3. бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах;	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх шаардлагын дагуу бүсийн төв болгон хөгжүүлэх, хотуудын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагын дагуу дунд хугацааны болон богино хугацааны аймгийн бодлогын баримт бичигт тусган хөрөнгө оруулалт болон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглах, ашиглалтыг сайжруулах чиглэлээр идэвх санаачлагатай ажиллаж, үр дүнг тооцон тайлагнаж ажиллаж байна.	30,0
15.2.4.. бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах;	Бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах ажлыг эрчимжүүлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна.	30,0
МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ / 2022-11-11 / УИХ-ын тогтоол Дугаар 72 1.10. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэдэд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг үзүүлэх.	2023 оны 07 дугаар сараас дахин хуваарт нислэгтэй болж Аймгийн 100 жилийн ойтой холбоотой онгоцны тийзний үнийн хөнгөлөлтийг үзүүлж байсан.МИАТ ТӨХК хямдралтай нислэгүүдийг цаг тухай бүрд тогтмол үйлдэж байгаа бөгөөд Орон нутгийн зүгээс санхүүжилттэй холбоотой нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлт үзүүлэх боломжгүй байна.	30,0
Ноос ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай / 2021-04-06 / УИХ-ын байнгын хорооны тогтоол	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд "Өүлэн мөнч" ХХК -ийн сурагчийн дүрэмт хувцасны ноосон давуун	30,0



Дугаар - 02 4/Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд төрийн албан хаагчийн болон сурагчийн дүрэмт хувцасны ноосон даавуу, драп болон сүлжмэл эдлэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх.	үйлдвэрлэлийг дэмжиж орон нутагт борлуулах цэгийг Баруун бүсийн худалдааны төвд байршуулан худалдан авалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.	
Чиглэл өгөх тухай / 2022-06-15 / УИХ-ын байнгын хорооны тогтоол Дугаар 07 1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	Аймгийн 20 сум таримал тэжээл тариалж амжилттай ургац хураан авснаар өнгөрсөн оноос 8952 тонноор илүү тэжээлийг хураан авчээ. 2022 онд тус аймгийн 18 сум 3603 га-д тариалалт хийж, 4768.1 тонн тэжээлийг хураан авсан байна. Малын тэжээл тариалалт жил бүр нэмэгдэж байна. Завхан аймгийн Асгат Тэлмэн, Түдэвтэй сумдад газар тариалан эрхлэх гол нөөц газруудыг шийдвэрлэж өгсөн. Улиастай Тосонцэнгэл сумдын дулааны болон цахилгаан станцын угсралтын ажил хийгдэж байна ажлын чиглэлээр 2024 оны 6 сард ашиглалтад орно. Тус станцууд ашиглалтад орсноор сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл байгуулах орчин нөхцөл бүрдэнэ.	30
Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 02 1.2/ Импортлогч улсын хорио цээрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Тосон Мах Маркет" ХХК "Эрдэнэт мах маркет" ХХК-д мах бэлтгэн нийлүүлэх гэрээний дагуу 2022 оноос хойш Эрдэнэт хот руу мах нийлүүлэн ажиллаж байна.	30
Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай / 2023-12-20 / ЗГ-ын тогтоол Дугаар 458 2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах	Завхан аймаг өвлийн аялал жуулчлал зохион байгуулахад ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд өвлийн аялал жуулчлалын чиглэлээр эвент арга хэмжээ зохион байгуулахад хөрөнгө санхүүгийн асуудал тулгарч байна.	30

Хэрэгжилт нь хангалтгүй дээрхи тогтоолууд нь 2023 оны эцсээр батлагдсан бөгөөд бэлтгэл ажил хангагдаж байна. Эдгээр заалтын хэрэгжилтийг 2024 онд эрчимжүүлж хэрэгжүүлэх талаар хэлтсийн даргын албан тоотоор хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

Үнэлгээний дүгнэлт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар 102 шийдвэрийн орон нутагт даалгасан 195 заалтыг хяналтанд авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, 87.43 хувьтай үнэлэгдлээ.




Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, явцад хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж, үр дүнг аймаг, сумын удирдлагад танилцуулан эрчимжүүлэх шаардлагатай асуудлыг тодорхойлон заавар, зөвлөмжийг өгч хэрэгжилтийг ханган ажиллахад хяналт тавьж ажиллалаа.

Хурлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хэлэлцсэн шийдвэр гаргуулан Засгийн Газрын Хяналт Хэрэгжүүлэх газарт уламжилж байна.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутагт холбогдолтой тусгагдсан 17 заалт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг бодлого, зорилт тус бүрээр авч үзвэл: Эдийн засгийн бодлогын хүрээнд 5 зорилтын 5 арга хэмжээ, Засаглалын бодлогын хүрээнд 1 зорилтын 3 арга хэмжээ, Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 3 зорилтын 3 арга хэмжээ, Нийслэл болон бүс орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 6 зорилтын 6 арга хэмжээг тус тус хяналтад авсан ба нэгдсэн үнэлгээгээр 80 хувийн хэрэгжилттэй байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцохдоо хөтөлбөрийн батлагдсан хугацаанаас эхэлж хийж хэрэгжүүлсэн ажлын явцаар тайлагнасан болно.



Үнэлгээний дүгнэлт



Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бодлого, 15 зорилтын 17 арга хэмжээг хяналтанд авч орон нутагт хэрэгжүүлэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцыг хэлэлцүүлж орон нутагт даалгасан заалтуудыг эрчимжүүлж ажиллахыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт чиглэл өгч, холбогдох дээд шатны байгууллагатай уялдаа холбоотой ажиллахыг үүрэг болгосон.

2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 52,9 хувийг үр дүнтэй, 47.1 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй ажил болгохоор орон нутгийн бодлогын баримт бичиг, 2024 оны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллахаар төлөвлөсөн байна.


3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө нь 5 бодлого, 17 зорилт, 265 арга хэмжээ (2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 69 дугаар тогтоолоор 41 арга хэмжээ, 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 80 дугаар тогтоолоор 47 арга хэмжээ тус тус нэмэлт өөрчлөлт орсон)-гээр төлөвлөгдөж хэрэгжилт 90.53 хувийн биелэлттэй буюу **ТОДОРХОЙ ҮР ДҮНД** хүрсэн гэж дүгнэгдсэн.

4. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 бодлого, 27 зорилт, 282 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж хэрэгжилт 81.91 хувийн биелэлттэй буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэгдсэн.

Аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн зурган тайлантай дараах QR кодыг уншуулан танилцана уу.



5.Аймгийн эдийн нийгмийн хөгжлийн 45 үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцохдоо 2023 оныг 2022 онтой харьцуулан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг холбогдох хэлтэс, агентлагуудаас мэдээллийг авч, ҮСХорооны www.1212.mn цахим хуудсанд байрших албан ёсны статистик мэдээ, холбогдох байгууллагуудын мэдээлэлтэй уялдуулан нягталж, нэгтгэн гаргалаа.

Аймгийн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт болох эдийн засгийн хөгжлийн 21 үзүүлэлт 82.86 хувь, нийгмийн 24 үзүүлэлт 83.75 хувь, нийт дүнгээр **83.3** хувийн гүйцэтгэлтэй байна.



Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээнд:

2023 оны дотоодын нийт бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ статистик мэдээгээр 2024 оны 6 сард гарах учир 2022 оны дотоодын нийт бүтээгдэхүүний тоо, хэмжээгээр үзүүлэлтийг тооцсон болно.

Жижиг дунд үйлдвэрийн зээлийн эргэн төлөлтийн хувь өмнөх оноос буурсан нь өмнөх жилүүдэд Жижиг дунд үйлдвэрийн дэмжих сангийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг шүүхэд шилжүүлж төлүүлсэн, мөн график төлөлтөндөө орж байгаатай холбоотой байна.

Хэрэглээний үнийн индексийг 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 115,8 буюу 15,8 хувиар өссөн бол 2023 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 106,2 хувь буюу 6,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь Үндэсний Статистикийн хорооны хэрэглээний үнийн индекс тооцоолох аргачлал дээр суурь оноо 2023 оноос өмнөхийг 2015 оноор, 2023 оноос хойш суурь оныг 2020 оноор тооцоолдог болсонтой холбоотой юм.

Малын тоо 2020 оноос хойш 3 жил дараалан буурч байгаа нь малчид газрын гарц муу, өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байсан тул зах зээлийн эргэлтэнд оруулж борлуулалт их хийсэн байна.

Мөн 2023 онд малын тэжээл тариалалт нэмэгдсэн боловч үр тариа, хүнсний ногооны ургац өмнөх оноос буурсан нь байгаль цаг ууртай холбоотойгоор газрын гарц муу, хур бороо муу байснаас шалтгаалсан байна.



Нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээнд:

PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж 2022 онд 25 байсан бол 2023 онд 19, PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж 2022 онд 39.0 байсан бол 2023 онд 25 болж буурсан байна. Энэ нь агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр усан халаалттай 15-100 кВт хүчин чадалтай 1 зуух цахилгаан, 1 зуух төвлөрсөн халаалтанд холбогдсон, 2 зуух нэгдэж, 4 зуухны үйл ажиллагаа зогссон, Их-Уул сумын 9 зуух, Отгон сумын 8 зуух 101-4200 кВт төвлөрсөн халаалтанд холбогдсон зэргээс шалтгаалсан байна.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2022 онтой харьцуулахад 2,2 промилээр өссөн боловч 2019 оны суурь түвшингөөс 2,0 промил, 2023 оны зорилтот түвшингөөс 1,4 промилээр буурсан үзүүлэлттэй байна.

Энэ нь Хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарыг түлхүү бэлтгэх, сумдын эрүүл мэндийн төвийг хүүхдийн эмчтэй болгох зорилт тавин ажиллаж 10 гаруй сумыг хүүхдийн эмчтэй болгож, хүүхдийн яаралтай тусламжийн нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хангалтыг бүрэн хийсэн. Мөн Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт сурфактант эмчилгээг нэтрүүлсэн зэрэг шат дараалсан арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсэн нь нялхсын эндэгдэл буурахад гол нөлөө үзүүлж байна.

Артерийн даралтын ихсэх өвчний эрт илрүүлэг, чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт 2022 оноос өмнөх жилүүдэд зорилтот бүлэгт чиглэн хамруулж хамрагдалтын хувь өндөр байдаг байсан. 2022 оноос Эрүүл мэндийн сайдын тушаалаар 18 наснаас дээш насны иргэдийг хамруулдаг болсонтой холбоотой хамрагдалтын хувь бага харагдаж байна.

6. Засгийн газрын гишүүн аймаг нийгслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

Засгийн газрын гишүүн Аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллахаар 19 гэрээ байгуулагдаж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн дундаж 92.5 хувийн биелэлттэй байна.

Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.

7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт



Аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөн нь 17 зорилт 79 арга хэмжээгээр төлөвлөгдөж, төлөвлөгөөний биелэлт 98.7 хувийн биелэлттэй байна.

Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.

8. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Аймгийн Засаг даргын Тамгын газрын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 7 үйл ажиллагаа, 26 шалгуур үзүүлэлттэйгээр төлөвлөгдөн хэрэгжилт нь 98.57 хувийн биелэлттэй байна.

Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.

9. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 5 зорилт 44 арга хэмжээг хяналтад авч, 2023 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжилт 91.82 хувийн биелэлттэй байна.

10. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Завхан аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, заавар зөвлөмжөөр ханган ажиллалаа.

Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэн төсвийн зарцуулалтад иргэдийн оролцоо, хяналтыг бий болгон, тайлагналтад улирал тутам хяналт тавин ажиллаж байна.


Шилэн дансны хэрэгжилтийг хангуулах зорилгоор төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд тусган хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажиллаж байна.

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын дагуу шилэн дансны хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчдийг мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Завхан аймаг дахь Төрийн аудитын



газар, Оюунлаг таны туслагч ТББ-тай хамтран 2023 оны 10 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл “Шилэн дансны тайлагналтыг эрчимжүүлэх” сарын аяныг зарлаж, мэдээлэл арга зүйгээр ханган идэвхтэй хамрагдаж шилэн дансны хэрэгжилтийг эрчимжүүлсэн мөн түүний хүрээнд бүтээлч ажил зохион байгуулсан хэлтэс, агентлагуудыг шагнаж, урамшуулсан.

Шилэн дансны системд нийт 232 байгууллага бүртгэлтэйгээс Аж ахуй нэгж, Төрийн бус байгууллага-4, Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар- 9, Төсөвт байгууллага- 210, Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компани- 6 , Засгийн газрын тусгай сан - 3 байна. Эдгээр байгууллагууд төрийн байгууллагын шилэн дансны сайт болон өөрийн байгууллагын шилэн дансны хуудас, мэдээллийн самбарт мэдээллээ байршуулан иргэдэд ил тод нээлттэй мэдээллэн ажиллаж байна.



Завхан аймгийн Засаг даргын тамгын газар

И-мэйл:
zavkhan.ZDTG@gmail.com

Ажлын утас:
70462454

Шуудангийн хаяг:
Сошиал хаяг:
Завхан аймгийн Засаг даргын тамгын газар

Нэр т...

Дэлгэр

Салбар

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Заавал эсэх	1	2	3	4	5	6	7	8	9
	Хайлт хийх	Хайлт хи...	Хайлт хийх										
Сар бүр													
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Хөтөлбөр, зориулалт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

2023 онд аймгийн хэмжээнд шилэн дансны хөтлөлтөд 232 байгууллагын 33132 мэдээллийг сайтад байршуулж 97.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Д/д	Байгууллага, нэгжийн нэр	Байгууллага, нэгжийн тоо	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хэрэгжилтийн хувь
1	Төсвийн байгууллага	210	31458	30691	97.6
2	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компани	6	868	843	97.1
3	Аж ахуй нэгж ,төрийн бус байгууллага, иргэн	4	16	14	87.5



4	Төрийн болон орон нутгийн үйлдвэрийн газар	9	1241	1152	92.8
5	Засгийн газрын тусгай сан	3	432	432	100.0
	ДҮН	232	34015	33132	97.4

Шилэн дансны хөтлөлтөд Эрдэнэхайрхан хөгжил орон нутгийн өмчит аж ахуй нэгж үйлдвэрийн газар- 45.5%, Яруу сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал- 68.2%, Яруу сумын Засаг даргын Тамгын газар- 71.6%, Биеийн тамир спортын газар- 70.4%, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар- 73.3%- тай байршуулсан нь аймгийн дундаж хувьд сөргөөр нөлөөлсөн байна.

2023 онд шилэн дансны хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн Алдархаан сумын Засаг дарга, Дөрвөлжин сумын Засаг дарга, Алдархаан сумын Засаг даргын Тамгын газарт тус тус хариуцлага тооцох санал хүргүүлсэн.

11.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн, хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд тусган хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг батлагдсан загварын дагуу гаргахад хэрэгжилтийн хувь 89.2 хувийн биелэлттэй байна. Үүнд: Ногоон байгууламж 90.0 хувь, Цахим шилжилт 92,5 хувь, Хог хаягдлын менежмент 85,0 хувийн биелэлттэй байна.

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Монгол улсын ерөнхийлөгчийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” өрнүүлэх 58 дугаар зарлигийн хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мод үржүүлгийн газруудын тарьц, суулгацын тоо хэмжээ, үнийн санал, мод тарих арга аргачлал, заавар зөвлөмж, мод тарих уриалгыг 24 сум, Улиастай сумын 94 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж мод тарих ажлыг 5, 10 дугаар саруудад зохион байгуулсан.

Мод тарих, арчлан ургуулах сургалтыг 24 сумын байгаль хамгаалагч, Улиастай сумын 50 аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилчдын дунд зохион байгуулж, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлаар 532197 ширхэг мод, бут тарьж, мод үржүүлгийн газруудад үр болон мөчрөөр 2556848 ширхэг, тарьц суулгац үржүүлж, аймгийн хэмжээнд нийт 3089045 ширхэг мод тарьсан байна.



Мод тарих ажилд 198 аж ахуйн нэгж байгууллага, 8080 иргэн, 1,9 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үүнээс 6006 ширхэг мод, бутыг 576 айл өрх хашаандаа 80,64 га талбайг хашиж хамгаалан мод бут тарьж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.

Цахим шилжилтийн хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И Монгол академитай хамтран Орон нутгийн 14 байгууллагын 50 үйлчилгээг цахимжуулж, ер.е Mongolia системд 47 байгууллагыг холбон, 24 сумдын 100 гаруй байгууллага тус системтэй холбогдсон.

Аймгийн хэмжээнд нийт насанд хүрсэн 49,7 мянган иргэний 15,0 мянга буюу 30,1 хувь нь E-Mongolia цахим үйлчилгээнд хамрагдсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 39028 тн хог хаягдал үүссэн. Үүний 508,4 тн хог хаягдлыг дахин боловсруулсан буюу 1,3 хувь дахин боловсруулсан байна. Энэ нь 2013-2022 онуудад уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэн хуримтлагдсан хог хаягдлыг дахин боловсруулах шаардлагыг удаа дараа хүргүүлсний үр дүнд 2023 онд эрх бүхий байгууллагад шилжүүлсэн байна.

Асгат, Завханмандал, Идэр, Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Түдэвтэй, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Улиастай, Эрдэнэхайрхан сумд хог хаягдлын төвлөрсөн цэгийг шууж тохижуулах, га талбайг багасгах, мөн Улиастай сумын эргэн тойронд иргэдийн дур мэдэн үүсгээд удсан 8 хогийн цэгийг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, 26,4 га талбайн 650м³ хогийг нэгдсэн хогийн цэгт хүргэж, зориулалтын бус хогийн цэг дахин үүсэх эрсдэлийг тооцож, хяналтын камерыг суурилуулан хог хаягдал тээвэрлэх, зөөвөрлөх техник хэрэгслээр үе шаттайгаар ханган ажиллаж байна.



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ТУЯА

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БЯМБАДОРЖ

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА

Г.МЯГМАРСҮРЭН

